



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 10 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 10 дугаар хуралдаан 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар /2025-05-09/ ХХЗХ-ны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдааны 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” (“Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”) Хорооны баталсан 2025 оны 98 тоот тогтоол, 99 тоот тогтоол, 100 тоот тогтоол, 101 тоот тогтоол, 102 тоот тогтоолын хэрэгжилтийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 15 (Тогтоол №103-113, 2025-05-09) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар (2025-05-08) “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” Хорооны баталсан 2025 оны 98 тоот тогтоол, 99 тоот тогтоол, 100 тоот тогтоол, 101 тоот тогтоол, 102 тоот тогтоолын хэрэгжилт, тогтоолын 2 дугаар заалт (Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай) болон 3 дугаар заалт (Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг эрэмблэгдсэн нэр бүхий 5 ААН, хуулийн этгээд нарт мэдэгдсүгэй)-ыг тогтооосон хугацаанд хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэг, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах-д тус тус үүрэг болгосон билээ.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 10 дугаар хуралдаанд Үнэлгээний ажлын хэсгээс зохицуулах хорооны баталсан 2025 оны 98 тоот тогтоол, 99 тоот тогтоол, 100 тоот тогтоол, 101 тоот тогтоол, 102 тоот тогтоолыг хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох танилцуулга, шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулсан радио давтамжийн зурвасын сонголт, тогтоолын төслийг тус тус хэлэлцээд, Хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дараах “Тусгай зөвшөөрөл олгох тухай” 4 тогтоолыг (Тогтоол №103-106) баталсан болно. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай

хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 98 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 103 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Юнител ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3500-3600 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; Юнител ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.”;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 104 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Мобиком Корпораци ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3600-3700 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; Мобиком Корпораци ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.”;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 105 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Скайтел ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3700-3800 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; Скайтел ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.”;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус

хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 101 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 106 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Жимобайл ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3300-3400 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; Жимобайл ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэж тус тус шийдвэрлэсэн.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 107 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдэд 6 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 108 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ашид шуудан ХХК: Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Шуудангийн нэмэлт үйлчилгээ/) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 109 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Сод электроникс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 110 тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд (Салхи энтертейнмент ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” зөвшөөрлийн хамрах хүрээ) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Салхи энтертейнмент ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 111 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн

- 1 тусгай зөвшөөрлийг (Салхи энтертейнмент ХХК: “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800200 тоот тусгай зөвшөөрөл) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Глобал тракинг систем ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 112 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Глобал тракинг систем ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200207 тоот тусгай зөвшөөрөл) хүчингүй болгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 113 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн (Монгол Улсын Ерөнхий прокурорын газар; Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай сунган тус тус шийдвэрлэв.

Тус хорооны хуралдаанаас Үнэлгээний ажлын хэсэгт батлагдсан 2025 оны 102 тоот тогтоолын хэрэгжилтийг хугацаанд хэрэгжүүлэх удирдамж, чиглэл өгч, Ондо ХХК-д тогтоолын 2 дугаар заалт (Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай), 3 дугаар заалт (Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг эрэмблэгдсэн Ондо ХХК-д мэдэгдсүгэй)-ын дагуу заасан хугацаанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2025 оны 102 тоот тогтоолын хэрэгжилтийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэг, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах-д тус тус даалгав.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-05-13